

Ажлын хуудас №9

Энд дарж бичлэгийг үзнэ үү.

1. Хүүхдүүдээ аль улиралд өдөр уртасч, шөнө богиносдог билээ? Харин аль улиралд өдөр богиносч, шөнө уртасдаг вэ?

.....

.....

2. “Зуны улиралд өдөр уртасч, шөнө богиносдог, харин өвлийн улиралд өдөр богиносч, шөнө уртасдаг” гэж 1-р асуултад зөв хариулсан бол дараагийн сонирхолтой мэдээллүүдийг мэдэж аваарай.

Зун болон өвлийн туйлын өдрүүд гэж байдаг. Энэ өдрүүд нь хэзээ болдгийг мэддэг үү?

.....

Дараах хүснэгтийг сайн ажиглаж, өөрсдийнхөө бичсэнээ шалгаарай.

	Өвлийн туйл нь арван хоёрдугаар сарын 22		Зуны туйл нь зургадугаар сарын 22
---	---	--	---

3. Та нар өмнө өдөр, шөнө тэнцдэг гэдгийг сонсож байсан уу?

.....

.....

Дараах хүснэгтийг сайн ажиглаж, өөрсдийнхөө бичсэнээ шалгаарай.

	Намрын улиралд өдөр, шөнийн тэнцэл буюу есдүгээр сарын 22-нд дэлхийн бүх газар өдөр шөнө хоёр тэнцдэг. Харин хаврын улиралд гуравдугаар сарын 22-нд дэлхийн бүх газар өдөр, шөнө хоёр тэнцдэг.	
---	--	--